

ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬАТЫН ГАЗРЫН БУЯНТ-УХАА ДАХЬ ГАЗРЫН 2018 ОНЫ ЕСДҮГЭЭР САРД
ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮНДСЭН АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

/2018.08.26 - 2018.09.25/

2018 оны 09 дүгээр сарын 26

Буянт-Ухаа

Д/д	Зорилт	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлтийн хүрэх түвшин		Хариуцах албан хаагч	Хувь
1	2	3	4	5		
1.	Газрын үйл ажиллагааны чиглэлээр	Төв аймаг дахь төлөөллийн үйл ажиллагаа явуулдаг албан тасалгааг засч сайжруулах тооцоог хийх.	Холбогдох тооцоог хийж, засвар хийх бэлтгэл ажлыг хангасан байна.	Тус газар нь Төв аймгийг хариуцан ажилладаг бөгөөд байгууллагын даргын тушаалаар Төв аймаг дахь ахлах мэргэжилтэнийг 2018.09.10-ны өдрөөс томилон ажиллуулж байгаатай холбогдуулан уг төлөөллийн үйл ажиллагаагаа явуулах албан тасалгаанд засвар хийх тооцоо судалгааг гаргасан бөгөөд 2018.09.13-наас 18-ны өдрүүдэд засвар хийж тохижуулсан.	Хяналтын улсын ахлах байцаагч З.Даваасүрэн Төв аймаг дахь ахлах мэргэжилтэн З.Өлзийбаяр, ахлах нягтлан бодогч Ц.Энхтуяа	100
2.	Дээд шатны байгууллагыг мэдээллээр хангах чиглэлээр	Газрын үйл ажиллагааны тайлан, төлөвлөгөө, төлөвлөгөөний биелэлтийг нэгтгэж Гадаадын иргэн, харьяатын газрын холбогдох нэгжид хугацаанд нь хүргүүлэх.	Тайлан, төлөвлөгөөний биелэлт, хийх ажлын төлөвлөгөөнд тусгах саналыг байгууллагын хөдөлмөрийн дотоод журамд заасан хугацаанд албан хаагчдаас авч, нэгтгэн ГИХГ-ын Боомт, орон нутгийн хэлтэст хүргүүлсэн байна.	Захиргаа, Төв аймаг дахь төлөөлөл, боомтод ажиллаж буй 4 ээлжээс хийсэн ажлын тайлан, төлөвлөгөөний биелэлт, хийх ажлын төлөвлөгөөнд тусгах саналыг байгууллагын Хөдөлмөрийн дотоод журамд заасан хугацаанд авч, нэгтгэн Боомт, орон нутгийн хэлтэст хүргүүлсэн байна. Тухайлбал, тус газрын энэ оны есдүгээр сарын үйл ажиллагааны тайланг 2018.09.26-ны өдөр 12/104 дүгээр албан бичгээр хүргүүлсэн.	Захиргааны ахлах мэргэжилтэн С.Онгонзаяа	100

1	2	3	4	5	6	7
				Харин аравдугаар сард хэрэгжүүлэх үндсэн арга хэмжээний төлөвлөгөө, есдүгээр сард хэрэгжүүлэх үндсэн арга хэмжээний төлөвлөгөөний биелэлтийг 2018.09.26-ны өдөр цахимаар хүргүүлсэн болно.		
3.		Байгууллагын инфографик мэдээнд тусгах статистик тоог гаргаж холбогдох нэгжид хүргүүлэх ажлыг зохион байгуулах.	Тоон мэдээг 2017 онтой харьцуулан гаргаж Боомт, орон нутгийн хэлтэст хүргүүлсэн байна.	ГИХГ-аас гаргадаг инфографик мэдээнд тусгах тус газрын 2018 оны есдүгээр сарын статистик тоог 2017 оны мөн үетэй харьцуулан гаргаж Боомт, орон нутгийн хэлтэст 2018.09.25-ны өдөр цахимаар хүргүүлэв. Мэдээгээр 2017.08.26-2017.09.25-ны өдрийн байдлаар тус газарт ирсэн бичиг 8 үүнээс харицтай албан бичиг 4, явсан бичиг 11, ирсэн өргөдөл 1, гомдол 0 байсан бол 2018.08.26-2018.09.25-ны өдрийн байдлаар тус газарт ирсэн бичиг 15 үүнээс хариутай албан бичиг 8, явсан бичиг 17, ирсэн өргөдөл, гомдол 0 байна.	Захиргааны ахлах мэргэжилтэн С.Онгонзаяа	100
4.		Байгууллагын даргын батлан гаргасан албан даалгаврын биелэлтийг гаргаж холбогдох нэгжид хүргүүлэх ажлыг зохион байгуулах.	Биелэлтийг үнэн зөв гаргаж Боомт, орон нутгийн хэлтэст хүргүүлсэн байна.	Байгууллагын даргын батлан гаргасан 2017 оны 01, 03, 04, 05, 06, 07, 2018 оны 02, 04, 06, 08, 09, 10 дугаар албан даалгаврын биелэлтийг гаргаж Боомт, орон нутгийн хэлтэст 2018.08.30-ны өдөр хүргүүлэв.	Нийт албан хаагчид	100

1	2	3	4	5		
5.	Виз, бүртгэлийн чиглэлээр	Гадаадын иргэнд виз олгох, визний шилжүүлэг хийх, бүртгэл, хасалтын үйлчилгээ үзүүлэх.	Төрийн үйлчилгээг гадаадын иргэнд түргэн шуурхай үзүүлсэн байна.	Нийт 83 орны 599 гадаадын иргэнд зохих ангилал, зориулалтын визийг олгосон бөгөөд үүнээс визийн шилжүүлэг 3 байна. Тухайлбал, нэг удаагийн орох 555, хоёр удаагийн орох 3, олон удаагийн орох 6, нэг удаагийн гарах-орох 16, хоёр удаагийн гарах-орох 0, олон удаагийн гарах-орох 2, дамжин өнгөрөх 14, түр ирэгчийн бүртгэл 140, хасалт 158, оршин суух зөвшөөрлийн хасалт 30 байна.	Виз, зөвшөөрлийн ахлах мэргэжилтэн, Хяналтын улсын байцаагч нар	100
6.		Монгол Улсын визгүй, хориг арга хэмжээ авагдсан гадаадын иргэнийг буцаах арга хэмжээ авч ажиллах.	Гадаадын иргэний мэдээллийг "ISM" систем дээр шалгаж визгүй, хориг арга хэмжээтэй гадаадын иргэнийг хил нэвтрүүлэлгүй буцаасан байна.	Монгол Улсын виз, визийн зөвшөөрөлгүй, ирсэн зорилгоо тодорхойлж чадаагүй зэрэг үндэслэлээр нийт 4 орны 10 гадаадын иргэнийг Монгол Улсын хилээр оруулаагүй буцаасан ба гарах визгүй, аж ахуйн нэгжийн албан бичиггүй зэрэг үндэслэлээр нийт 13 орны 17 гадаадын иргэнийг Монгол Улсын хилээр гаргаагүй болно.	Виз, зөвшөөрлийн ахлах мэргэжилтэн, Хяналтын улсын байцаагч нар	100
7.	Хяналт шалгалтын чиглэлээр	Төв аймагт нийтийн хоол, боловсрол, шашны чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, байгуулагад хөдөлмөр эрхэлж байгаа гадаадын иргэдэд хяналт шалгалт хийх.	Удирдамж батлуулан хяналт шалгалтыг зохион байгуулж, дүнг Буянт-Ухаа дахь газрын даргад танилцуулсан байна.	Төв аймгийн Гэмт хэргээс хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн 2018.09.10-ны өдрийн 16 дугаар тогтоолын дагуу тус аймгийн тагнуул, Засаг даргын Тамгын газар, болон цагдаагийн байгууллагатай хамтран тус бүр 4 хүний бүрэлдэхүүнтэй 4 ажлын хэсэг гарч энэ сарын 10-наас 13-ны өдрүүдэд шалгалт хийв.	Хяналтын улсын ахлах байцаагч З.Даваасүрэн Хяналтын улсын байцаагч нар	100

1	2	3	4	5	6	7
				Тус хяналт шалгалтад нийтийн хоолны 1, боловсрол 1, шашны байгууллага 41, ААН 12, 2 орны 108 гадаадын иргэн хамрагдсан бөгөөд зөрчил илрээгүй ба дүнг илтгэх хуудсаар тус газрын даргад 2018.09.20-ны өдөр танилцуулсан.		
8.		Зөрчлийн тухай хуулийн дагуу ГИЭЗБТХууль зөрчсөн гадаадын иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын зөрчлийг арилгаж, зөвлөгөө мэдээлэл өгч ажиллах.	Зөрчил гаргасан гадаадын иргэн, ААН, байгууллагын зөрчлийг шийдвэрлэж, зөвлөгөө мэдээлэл өгсөн байна.	Бүртгэлийн талаар тогтоосон журам зөрчсөн, визийн хугацаа хэтрүүлсэн, оршин суух журам зөрчсөн зэрэг үндэслэлээр 61 гадаадын иргэнд 5,160,000 төгрөг, 13 аж ахуйн нэгжид /хамрагдсан гадаадын иргэн 27/ 14,020,000 төгрөг, 2 уригч иргэнд /урьсан гадаадын иргэн 2/ 500,000 төгрөгийн торгуулийн арга хэмжээ авч, зөрчлийг арилган, зөвлөгөө мэдээлэл өгч ажиллалаа.	Хяналтын улсын ахлах байцаагч, хяналтын улсын байцаагч нар	100
9.		Хууль тогтоомж зөрчсөн гадаадын иргэнийг илрүүлсэн тохиолдолд Монгол Улсаас албадан гаргах үйл ажиллагааг зохион байгуулах.	Холбогдох хууль тогтоомжийн дагуу арга хэмжээ авч, мэдээллийн нэгдсэн санд бүртгэл хийсэн байна.	Хуурамч баримт бичиг ашиглан хил нэвтрэхийг завдсан нийт 2 орны 3 гадаадын иргэнийг тус улсаас албадан гаргах дүгнэлт үйлдэж байгууллагын даргын тушаалын дагуу Монгол Улсаас албадан гаргаж мэдээллийн нэгдсэн санд бүртгэл хийв.	Хяналтын улсын ахлах байцаагч, хяналтын улсын байцаагч нар	100
10.		Визгүй зорчдог болон хоригт багтсан орны иргэдэд хил дээр тавих хяналтыг сайжруулж ажиллах.	Хил дээр тавих хяналт сайжирсан байна.	Монгол Улсад визгүй зорчигч болон хоригт багтсан гадаадын иргэн, хөдөлмөр эрхлэх магадлалтай 8 орны 202 иргэнтэй ярилцлага хийж бичиг баримтыг хуулбарлан хилээр гарсан байдалд хяналт тавьж бүртгэл хөтөлсөн болно.	Хяналтын улсын ахлах байцаагч, хяналтын улсын байцаагч, мэргэжилтэн нар	100

1	2	3	4	5	6	7
11.		Төрийн албаны зөвлөлийн програмд албан хаагчийн талаарх мэдээллийг шинэчилж оруулах.	Төрийн албаны зөвлөлийн цахим програмд баяжилт хийсэн байна.	Байгууллагын даргын 2018 оны Б/233, Б/249 дүгээр тушаалаар тус газарт томилогдон ажиллаж буй сүлжээний инженер, Төв аймаг дахь ахлах мэргэжилтэн нарын талаарх мэдээллийг Төрийн албаны зөвлөлийн цахим програмд оруулав.	Захиргааны ахлах мэргэжилтэн С.Онгонзаяа	100
12.	Хүний нөөц, сургалтын чиглэлээр	Хуурамч баримт бичиг, түүнийг таних, тамга, тэмдэг ашиглахаас урьдчилан сэргийлэх чиглэлээр сургалт зохион байгуулах.	Бичиг баримтын хуурмаглалыг илрүүлэх чадварт суралцсан байна.	Гадаадын иргэн, харьяатын газраас БНХАУ-ын Бээжин хот дахь Нидерландын Вант Улсын Элчин сайдын яамтай хамтран 2018.09.06-ны өдөр зохион байгуулсан “Баримт бичгийн хуурмаглал илрүүлэх сургалтад тус газраас нийт 6 албан хаагч хамрагдав. Сургалтаар албан хаагчид хүний баримт бичиг ашигласан гадаадын иргэдийг хэрхэн илрүүлэх, хуурамч бичиг баримтын төрөл, дээрх бичиг баримт хэрхэн үйлдэгддэг талаар мэдээлэл авч мэдлэгээ дээшлүүлэв.	Хяналтын улсын ахлах байцаагч З.Даваасүрэн	100
13.		Жолооч нарт тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэгт холбогдохоос урьдчилан сэргийлэх зорилгоор холбогдох дүрэм, журмыг судлуулах.	Тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журмын эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэгдсэн байна.	Тус газар Иргэний агаарын тээвэр дэх Цагдаагийн хэлтэстэй хамтран жолооч нарт 2018.09.25-ны өдөр сургалт зохион байгуулав. Сургалтаар Иргэний агаарын тээвэр дэх Цагдаагийн хэлтийн ахлах зохицуулагч, ахмад Ц.Өнөрбат тус газрын жолооч нарт 2018.09.01-ний өдрөөс хэрэгжиж буй Замын хөдөлгөөний дүрмийн талаар хичээл оров.	Хяналтын улсын ахлах байцаагч З.Даваасүрэн	100

1	2	3	4	5			
14.		Мэдээллийн аюулгүй байдлын эсрэг хийж байгаа гэмт халдлагын төрөл, хийгдэх болсон шалтгаан, түүнээс урьдчилан сэргийлэх аргын талаарх сургалтыг зохион байгуулах.	Аливаа мэдээлэл гэмт халдлагад өртөгдөхөөс урьдчилан сэргийлэгдсэн байна.	Тасарсан		Сүлжээний инженер Б.Энхзаяа	0
15.		Архины хор хөнөөл, архидан согтуурахын хор уршгийн талаар сургалт зохион байгуулах.	Албанд архигүй орчныг бүрдүүлсэн байна.	Тасарсан		Хяналтын улсын ахлах байцаагч З.Даваасүрэн	0
16.		“Эрүүл аж төрөх ёс” сэдвийн хүрээнд нарийн мэргэжлийн эмчийг урьж, албан хаагчдад яриа, танилцуулга хийх.	Албан хаагчдын эрүүл мэндийг хамгаалах, аливаа өвчнөөс урьдчилан сэргийлэгдсэн байна.	Тасарсан		Виз, зөвшөөрлийн ахлах мэргэжилтэн Б.Ишханд	0
17.		“Терроризмтой тэмцэх эрх зүйн орчныг боловсронгуй болгох асуудал” сэдвээр мэдээлэл, сургалт зохион байгуулах.	Албан хаагчид зохих мэдлэгтэй болсон байна.	“Терроризмтой тэмцэх эрх зүйн орчныг боловсронгуй болгох асуудал” сэдвээр тус газрын албан хаагчдад 2018.09.04-ний өдөр сургалт зохион байгуулсан. Сургалтаар терроризмтой тэмцэх эрх зүйн орчныг боловсронгуй болгох хүчин зүйлс, өнөөгийн нөхцөл байдлын талаар мэдээлэв.		Виз, зөвшөөрлийн ахлах мэргэжилтэн Н.Золбаяр	100
18.		Хилийн боомтод ашиглах хэрэглээний гадаад хэлний гарын авлагаар сургалт зохион байгуулах.	Албан хаагчид гадаадын иргэдтэй харилцах хэлний мэдлэгээ дээшлүүлсэн байна.	Байгууллагын чиг үүргийг “Чингис хаан” ОУНБ-д хэрэгжүүлэхэд тус газрын албан хаагчид өдөр тутам гадаадын иргэдтэй харилцдаг тул 2018.09.04-ний өдөр “Хилийн боомтод ашиглагдах хэрэглээний гадаад хэлний гарын авлага”-г орсон герман, хятад, солонгос үг, хэллэгийн талаар сургалт зохион байгуулж албан хаагчид идэвхитэй хамрагдав.		Виз, зөвшөөрлийн ахлах мэргэжилтэн Б.Ишханд, Хяналтын улсын байцаагч С.Халиун, мэргэжилтэн Ц.Золзаяа	100

1	2	3	4	5	6	7
19.	Санхүү, хангамжийн чиглэлээр	Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах, өр авлагагүй ажиллах.	Төсөв санхүүгийн үр ашигтай тогтолцоог бүрдүүлэн ажилласан байна.	Батлагдсан төсвийг зохих зардлын дагуу зарцуулан өр, авлагагүй ажилласан. Батлагдсан төсөв болох өссөн дүнгээр 422,506,200 төгрөгийн санхүүжилт орсноор цалин хөлсөнд 240,859,486 төгрөг, ажил олгогчоос нийгмийн даатгалын шимтгэл 28,002,225 төгрөг, ХУДүүрэгт цалин хөлснөөс суутгасан ашгийн татварт 20,689,563 төгрөг, хангамж, бараа материалын зардалд 21,940,752 төгрөг зарцуулж өглөг авлага үүсгээгүй ажилласан.	Ахлах нягтлан бодогч Ц.Энхтуяа	100
20.		Төсвийн гүйцэтгэлийн мэдээ тайланг үнэн зөв гарган тогтоосон хугацаанд тайлагнах.	НД-ын шимтгэлийн тайланг дараа сарын 5, төсвийн гүйцэтгэлийн тайланг дараа сарын 2-ны өдрийн дотор гаргаж төсөв санхүүгийн үр ашигтай тогтолцоо бүрдсэн байна.	Төсвийн гүйцэтгэлийн мэдээг 2018.09.02-ны дотор гарган Хан-Уул дүүргийн Төрийн сангаар баталгаажуулан төвд хүргүүлсэн. Мэдээгээр 375,653,000 төгрөгийн урсгал санхүүжилт орсоноос нийт зарлага 304,829,363 төгрөгийн ажил үйлчилгээ явуулж өглөг авлагагүй ажилласан. Нийгмийн даатгалын шимтгэлийн тайланг гарган 2018.09.05-ны дотор Нийгмийн даатгалын хэлтэст хүргүүлэн 53,358,619 төгрөгөөр тооцоо нийлэв.	Ахлах нягтлан бодогч Ц.Энхтуяа, Нярав	100
21.		Үнэт цаасны тооцоо, авто машин ашиглалтын болон шатах тослох материалын тооцоог хугацаанд нь гаргаж, бүртгэл хөтлөн ажиллах.	Бүртгэл тооцоо хугацаандаа чанартай хийгдсэн байна.	Албан хаагчдад үнэт цаас болох визийн хуудас 600 ширхэгийг шаардах хуудасны дагуу олгосон. Түүнчлэн авто машины ашиглалт болон шатах тослох материалын тооцоог жолооч дэвтэрт бичилтийг хийн бүртгэл хөтлөв.	Ахлах нягтлан бодогч Ц.Энхтуяа	100

1	2	3	4	5		
22.		Төсвийн хүрээнд худалдан авалт хийх, албан хаагчдын ажиллах нөхцлөөр хангаж ажиллах.	Шаардлагатай бараа материалын худалдан авалт хийж шаардах хуудасны дагуу бараа материалыг тухай бүр нь гаргаж өгсөн байна.	Хангамж, бараа материалын зардалд өссөн дүнгээр 21,940,752 төгрөгийн худалдан авалт хийж, албан хаагчдыг шаардлагатай бараа материалаар хангаж ажилласан.	Ахлах нягтлан бодогч Ц.Энхтуяа, Нярав	100
23.		Албан хэрэгцээнд ашиглаж буй суурин утас, шуудангийн болон боомтод байрлах албан хаагчдын ажлын байрны түрээсийн төлбөр тооцоог нэхэмжлэхийн дагуу тухай бүр шийдвэрлэх.	Нэхэмжлэхийн дагуу тухайн байгууллагын холбогдох дансруу шилжүүлэн өглөг авлагагүй ажиллана.	Албан хэрэгцээнд ашиглаж байгаа суурин утас болон интернетийн төлбөрт 2,498,810 төгрөг, байрны түрээс 15,990,000 төгрөг харилцагч байгууллагын нэхэмжлэхийн дагуу холбогдох данс руу шилжүүлсэн.	Ахлах нягтлан бодогч Ц.Энхтуяа	100
24.		Татварын улсын тэмдэгтийн хураамж, хүү, торгуулийн тайланг гаргаж тооцоо нийлэх.	Хяналтын улсын байцаагч нараас тайланг авч тулган, сар бүрийн 5-ны дотор төвд хүргүүлсэн байх.	Хүү торгууль 13,950,000 төгрөгийг Төв аймгийн төрийн санд, визийн тэмдэгтийн хураамж 97,554,080 төгрөг, визийн хуудас 7,664,980 төгрөгөөр тайлан нэгтгэн Хяналтын улсын байцаагч нартай тооцоо нийлэн 2018.09.05-ны өдрийн дотор ГИХГ-ын Санхүүгийн хэлтэст хүргүүлсэн.	Ахлах нягтлан бодогч Ц.Энхтуяа	100
25.		Бараа материалын тайлан, кассын тайланг тухай бүр гаргах.	Нягтлан бодох бүртгэлийн хуулийн дагуу анхан шатны баримтыг бүрдүүлэн ажилласан байна.	Бараа материалын болон шатахууны тайланг гаргахдаа Нягтлан бодох бүртгэлийн хуулийн дагуу анхан шатны баримтыг бүрдүүлэн гаргасан ба хянуулж баталгаажуулсан. Түлш шатах тослох материалын тайлан өссөн дүнгээр 13,954,800 төгрөгний зарцуулалт гаргаж тайлагнасан.	Ахлах нягтлан бодогч Ц.Энхтуяа, Нярав	100

1	2	3	4	5	6	7
26.		Газрын албан хаагчдын нийгмийн даатгал, эрүүл мэндийн даатгалын дэвтэрт холбогдох бичилтийг хийх.	Албан хаагчдын НДД, ЭМД-ын дэвтэрт бичилт хийж нийгмийн даатгалын байцаагчаар НДД-ийг баталгаажуулсан байна.	Тус газрын нийт 28 албан хаагч, хүүхэд асрах чөлөөтэй 1 албан хаагч, жирэмсний амралттай 1 албан хаагчийн нийгмийн даатгал, эрүүл мэндийн даатгалын дэвтэрт холбогдох бичилтийг хийж Хан-Уул дүүргийн Нийгмийн даатгалын хэлтсээр баталгаажуулав.	Нярав	100
27.	Өргөдөл, гомдлын чиглэлээр	Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас өргөдөл, гомдол гаргах бүрт бүртгэл хөтлөн, холбогдох албан хаагчид хүргүүлж, хуульд заасан хугацаанд шийдвэрлүүлэх.	Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага, албан хаагчаас гаргасан өргөдөл, гомдлыг хүлээн авч, хуульд заасан хугацаанд шийдвэрлүүлсэн байна.	Буянт-Ухаа дахь газарт ирсэн өргөдөл, гомдлыг цаасан болон цахим хэлбэрээр бүртгэж, уг өргөдөлд Бүртгэл-хяналтын карт хөтөлж, газрын даргад танилцуулан шийдвэрлүүлж, хариуг хүргүүлэн ажилладаг бөгөөд тайлант хугацаанд тус газарт ирсэн өргөдөл, гомдол байхгүй болно.	Захиргааны ахлах мэргэжилтэн С.Онгонзаяа	100
28.	Бичиг хэрэг, архивын үйл ажиллагааны чиглэлээр	Газарт ирсэн, явсан албан бичгийн бүртгэл хөтөлж, хариутай албан бичгийн шийдвэрлэлтэд хяналт тавьж ажиллах.	Ирсэн, явсан бичгийн бүртгэлийг хөтөлжсэн хариутай албан бичгийн хариуг хугацаанд нь хүргүүлсэн байна.	Төрийн албан хэрэг хөтлөлтийн үндсэн зааврын дагуу тус газарт ирсэн нийт 15 албан бичгийг цаасан болон цахим хэлбэрээр бүртгэж, Бүртгэл-хяналтын карт хөтлөн, газрын даргад танилцуулан цохолт хийлгэж, холбогдох албан хаагчид шилжүүлэн хариутай 8 албан бичгийн шийдвэрлэлтийн байдалд хяналт тавин ажиллалаа. Хариутай албан бичгийн шийдвэрлэлтийн талаар Бүртгэл-хяналтын картад тэмдэглэв. Түүнчлэн тус газраас 17 албан бичиг боловсруулж холбогдох байгууллагад хүргүүлэв.	Захиргааны ахлах мэргэжилтэн С.Онгонзаяа	100

1	2	3	4	5	6	7
29.		Тус газарт ирсэн, явсан албан бичиг, тус газрын даргын баталсан тушаалыг сканердаж цахим архив үүсгэх.	Ирсэн, явсан албан бичиг, тус газрын даргын баталсан тушаалыг сканердаж цахим архив үүсгэсэн байна.	Тус газрын цаасан суурьтай баримтыг цахим хэлбэрт шилжүүлэх ажлын хүрээнд ГИХГ-ын Буянт-Ухаа дахь газарт ирсэн 15, явсан 17 албан бичиг, энэ сарын төлөвлөгөө, түүний биелэлт, тайланг сканердаж цахим хэлбэрт шилжүүлсэн.	Захиргааны ахлах мэргэжилтэн С.Онгонзаяа	100
30.	Мэдээллийн технологийн чиглэлээр	Сүлжээний тасралтгүй үйл ажиллагааг ханган ажиллах.	Ирсэн дуудлагын дагуу засвар үйлчилгээг хийж хэвийн ажиллагаанд оруулсан байна.	Сүлжээний болон техник хэрэгслийн дуудлага хүлээн авч засварлан хэвийн ажиллагаад оруулав. Тухайлбал, “Чингис Хаан” ОУНБ-ын тус газрын харьяа явагчийн өрөөний интернет холболттой компьютерийн интернет сүлжээ ажиллахгүй байсныг 2018.08.27-ны өдөр засварлаж, “ISM” системийн “Тайлан” цонхны алдаатай 10.204.32.21 IP хаягийг 10.204.32.22 хаягаар сольж 2018.08.29-ны өдөр, Бичиг баримтын хуурмаглал шалгадаг төхөөрөмжүүд ажиллахгүй байсныг 2018.09.06-ны өдөр засварлан хэвийн ажиллагаанд оруулсан. Түүнчлэн 2 компьютер форматлан ашиглагдах програмуудыг суулган, 2018.09.13-ны өдөр “Чингис Хаан” ОУНБ дахь тус газрын ирэгч, явагчийн өрөөнүүдийн 5 компьютерийн хэрэгцээгүй ачаалагдсан програмуудыг устган вирусын програмыг уншуулан хурдыг ихэсгэв.	Сүлжээний инженер Б.Энхзаяа	100

1	2	3	4	5	6	7
31.	Олон нийттэй харилцах чиглэлээр	Төсвийн зарцуулалтын талаар Shilendans.gov.mn сайтад мэдээллийг тухай бүр оруулж, иргэд хүссэн мэдээллээ авах боломжийг бүрдүүлэх.	Шилэн дансны хуулийн хэрэгжилт болон төсвийн ил тод байдлыг ханган ажиллаж, мэдээг үнэн зөв оруулсан байна.	Төсвийн зарцуулалтын талаар Shilendans.gov.mn сайтад мэдээллийг шивж оруулсан. Тухайлбал, Төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбарын хамт, Тухайн жилийн төсөвт орсон нэмэлт, өөрчлөлт, Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ, Хөрөнгийн зардал, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл, концессын зүйлийн жагсаалт, гүйцэтгэл, Хөрөнгийн болон урсгал зардалд тусгагдсан арга хэмжээний тендерийн ерөнхий мэдээлэл, Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8, 9 дүгээр зүйлд заасан мэдэгдэл.	Ахлах нягтлан бодогч Ц.Энхтуяа	100
32.		Тус газрын үйл ажиллагаатай холбоотой мэдээллийг бэлтгэн байгууллагын цахим хуудсанд байршуулах ажлыг зохион байгуулах.	Тус газрын сарын төлөвлөгөө, биелэлт, тайлан, өргөдөл, гомдлын мэдээг байгууллагын цахим хуудсанд байршуулсан байна.	Тус газрын есдүгээр сарын төлөвлөгөө, наймдугаар сарын төлөвлөгөөний биелэлт, тайланг 2018.08.30-ны өдөр байгууллагын цахим хуудсанд байршуулж олон нийтийг мэдээллээр ханган ажиллалаа.	Захиргааны ахлах мэргэжилтэн С.Онгонзаяа, Сүлжээний инженер Б.Энхзаяа	100

1	2	3	4	5	6	7
33.	Цагдаагийн байгууллага, гадаадын иргэн, харьяатын байгууллагын хамтран ажиллах журмын хэрэгжилтийг хангах ажлын чиглэлээр	Төв аймгийн нутаг дэвсгэрт оршин сууж буй гадаадын иргэний мэдээллийг сүлжээнээс шүүж цагдаагийн хэсгийн байцаагч нарт хүргүүлэх, харилцан мэдээлэл солилцох.	Холбогдох сүлжээнээс шүүлт хийж, харилцан үнэн, зөв мэдээллээр хангасан байна.	Тус газар Төв аймгийн нутаг дэвсгэрт оршин сууж буй гадаадын иргэний мэдээллийг "ISM" сүлжээнээс шүүж 2018.09.25-ны өдөр Төв аймгийн цагдаагийн хэлтсийн эрүүгийн төлөөлөгч, дэслэгч Д.Цэрэнпилд хүргүүлсэн болно. Мэдээгээр тус аймагт нийт 23 орны 477, харьяалалгүй 1 хүн байгаа ба үүнээс ихэнхи хувийг БНХАУ-ын иргэд эзэлж байна.	Хяналтын улсын ахлах байцаагч З.Даваасүрэн	100
34.		Зөрчил гаргасан гадаадын иргэний зөрчлийн талаарх мэдээлэл, албадан гаргаж, орохыг хориглосон гадаадын иргэний талаарх мэдээлэл солилцох.	Мэдээлэл, харилцан байна.	Тус газар Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн дагуу захиргааны шийтгэл ногдуулсан болон албадан гаргаж, орохыг хориглосон гадаадын иргэний талаарх мэдээллийг "ISM" сүлжээнээс шүүж 2018.09.25-ны өдөр Төв аймгийн цагдаагийн хэлтсийн эрүүгийн төлөөлөгч, дэслэгч Д.Цэрэнпилд өгсөн болно.	Хяналтын улсын ахлах байцаагч З.Даваасүрэн	100

Төлөвлөсөн: 34
Биелсэн: 31
Хагас биелсэн: 0
Биелээгүй: 3
Хувь: 92